



МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон. Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2016. 09. 11 № 38

Асуулга тавих тухай

Аливаа улс орон баялаг бүтээгчдээ дэмжиж байж хөгждөг жамтай. Тийм ч учраас төрөөс үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгжүүдээ гаалийн татварын бодлогоор дэмжиж, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг гол зорилгоо болгож буй билээ.

"Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой ёсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох зорилт дэвшүүлсэн.

Түүнчлэн, Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлж, чөлөөлөх, Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-иас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгж болон нийт дотоодын үйлдвэрлэлийг гаалийн, татварын бодлогоор дэмжих тухай тодорхой зорилтууд туссан билээ.

2016 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, татварт ногдох орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, сумдад 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, сумдад 90 хувиар хөнгөлөх заалтыг тусгаж өгсөн ч хуулийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байна. Тухайлбал, Ховд аймагт бүртгэлтэй 1848 татвар төлөгч аж ахуйн нэгжээс ердөө 13 нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан гэсэн мэдээ байна.

Мөн манай улсаас экспортолж буй бараанд Европын холбооны Хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд 7200, Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд 9300 төрлийн бараанд тэдгээр улсын гаалийн тарифын хөнгөлөлтийг эдлэх боломжтой болсон ч энэ бололцоог бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаад баялаг бүтээгчид, хувийн хэвшлийнхэн шүүмжлэлтэй хандаж байна.


Тиймээс бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжээ гааль татварын бодлогоор дэмжих талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Бүс нутгийн хөгжлийг татварын хөнгөлөлтөөр дэмжих зорилгоор 2016 онд батлагдан одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд алслагдсан бүс нутагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа хэдэн аж ахуйн нэгж 50-иас 90 хувийн татварын хөнгөлөлт эдэлсэн, энэ нь нийт дунгээрээ хэдэн төгрөгт хүрсэн талаар;
2. Дээрх хуулийг олон нийтэд таниулах, иргэд аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайлангийн талаар;
3. Манай улсаас экспортолж буй бараанд Европын холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем /ХЕС буюу GSP/-ийн хүрээнд гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой 7200 төрлийн бараанаас өнгөрсөн хугацаанд хэдий хэмжээний экспортын бараа хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн тухай
4. Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /ЭЗТХ буюу EPA/-ийн хүрээнд гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой 9300 төрлийн бараанаас хэдэн төрлийн бараа экспортод гарч, ямар хэмжээний тарифын хөнгөлөлт эдэлсэн талаар;
5. Хөрш орнууд болох БНХАУ, ОХУ болон БНСҮ, Хойд Америк, Ази-Номхон далайн, Арабын орнуудын зах зээл рүү гаалийн татваргүй буюу татварын хөнгөлөлттэй нөхцлөөр бараа бүтээгдэхүүн экспортлох боломжийн хүрээнд Засгийн газар, Гадаад харилцааны яамны, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газраас хийж буй ажлын талаарх тодорхой мэдээлэл боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуултгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ